



Бага боловсролын “Хүн ба байгаль”-ийн бие даан суралцах ажлын дэвтрийн хариултын хуудас

Бүлэг сэдэв: **План ба газрын зураг**





Дэд сэдэв: **Зургийн таних тэмдгийг ашиглах**

Анги: **4 дүгээр анги**


Даалгавар	Хариултын мэдээлэл	Буруу хариултын шинжилгээ
1. Ойлгох түвшин	Даалгавар 1 Дараах сургуулийн хашааны план зургийг ажиглаад таних тэмдгүүдийг зөв харгалзуулаарай. 	
2. Ойлгох түвшин	2 Сургуулийн ойр орчмын план зургийг ажиглаад дараах асуултын зөв хариултыг дугуйлаарай.  1. Цөөрөм сургуулийн аль зүгт байна вэ? А. Зүүн Б. Зүүн өмнө В. Баруун Г. Урд 2. Эмнэлэг сургуулийн аль зүгт байна вэ? А. Баруун өмнө Б. Хойно В. Зүүн Г. Баруун 3. Сургуулийн хойд талд юу байна вэ? А. Цөөрөм Б. Цэцэрлэгт хүрээлэн В. Дэлгүүр Г. Цэцэрлэг 4. Наран сургуульдаа явахдаа ямар байгууллагын хажуугаар өнгөрөх вэ? А. Дэлгүүр Б. Цэцэрлэг В. Эмнэлэг	
3. Хэрэглэх түвшин	3 Сургуулийн эргэн тойронд зааврын дагуу дараах зүйлсийг зураарай. Зурахдаа зүг чигийн тэмдгийг ашиглаарай.  а. Сургуулийн хойд зүгт хөл бөмбөгийн талбай зураарай. б. Сургуулийн баруун урд зүгт мод зураарай. в. Сургуулийн зүүн талд засмал зам зураарай. г. Сургуулийн урд талд орон сууцны байр зураарай.	

Дэд сэдэв: **План зураг зурах**

Анги: **4 дүгээр анги**


Даалгавар	Хариултын мэдээлэл	Буруу хариултын шинжилгээ
1. Хэрэглэх түвшин	Даалгавар 1 Батын гэр сургуулийн баруун талд 600 м зайтай байдаг. Харин Оргилынх яг зүүн талд нь сургуулиас 400 м зайтай байдаг байна. Найзууд хоёр гэрээсээ сургууль хүртлэх замын план зургийг зуржээ. Хүүхдүүдийн зурсан зургийг ажиглаад доорх өгүүлбэрүүдийн ҮНЭН ☐ ХУДАЛ ☐ болохыг тодорхойлоорой. Батын зурсан зураг  Оргилын зурсан зураг  a. Бат сургууль ба айлуудын хоорондох зайг зөв тооцоолж зурсан байна. ☐ b. Оргил сургууль ба айлуудын хоорондох зайг зөв тооцоолж зурсан байна. ☐ c. Дөрвөлжин дэвтрийн 1 нүдний зайнд бодит хэмжээний 100 м-ийн хэмжээг багтааж зурсан байна. ☐ d. Дөрвөлжин дэвтрийн 2 нүдний зайнд бодит хэмжээний 100 м-ийн хэмжээг багтааж зурсан байна. ☐	
2. Ойлгох түвшин	2 Бат өөрийн сургуулийнхаа план зургийг зурах даалгавар авчээ. Батын сургууль тэгш өнцөгт хэлбэртэй бөгөөд урт, өргөнийг алхаж хэмжихэд өргөн нь 40 алхам, урт нь 100 алхам байжээ. Бат план зургаа хоёр янзаар зурсан байна. Батын зурсан зургийг ажиглаад бодит хэмжээг хэрхэн багасгасан болохыг ажиглаад өгүүлбэрийн дутуу үгийг нөхөж бичээрэй.   a) А зургийг зурахдаа дэвтрийн 1 нүдний зайг өөрийн10..... алхамтай тэнцүү байхаар тооцоолон зуржээ. b) Б зургийг зурахдаа дэвтрийн 1 нүдний зайг өөрийн20..... алхамтай тэнцүү байхаар тооцоолон зуржээ.	

Дэд сэдэв: **Хол ойр зайг яаж мэдэх вэ?**
Анги: **4 дүгээр анги**

Даалгавар	Хариултын мэдээлэл	Буруу хариултын шинжилгээ
1. Хэрэглэх	1 даалгавар Батынх зуны амралтаараа гэр бүлээрээ аялжээ. Тэд УБ → Өвөрхангай → Архангай → Говь-Алтай → Увс гэсэн маршрутаар явсаар зорьсон газраа хүрчээ. Явж байхдаа аймгуудын төвөөр заавал дайран өнгөрч байлаа. Аймгийн төвүүдийн хоорондох зайг шугам ашиглан хэмжээд багаас нь их рүү нь зөв эрэмбэлсэн бичсэн хувилбарыг олоорой.  A. УБ–Өвөрхангай , Өвөрхангай – Архангай , Говь-Алтай – Увс , Архангай – Говь-Алтай B. Өвөрхангай – Архангай , Говь-Алтай – Увс , Архангай – Говь-Алтай УБ–Өвөрхангай C. Өвөрхангай – Архангай , УБ–Өвөрхангай , Архангай – Говь-Алтай Говь-Алтай – Увс	
2. Ойлгох түвшин	2 Дээрх газрын зургийг ажиглаад дараах таних тэмдгүүд юуг илэрхийлж байгааг нөхөж бичээрэй. Таних тэмдэг :  — улсын хил — аймгийн хил  — аймгийн төв — нуур	
3. Хэрэглэх түвшин	3 Булган аймагтай хамгийн ойрхон буюу хамгийн хол аймгийг нэрлээрэй. Хамгийн ойрхон аймаг — Орхон аймаг Хамгийн хол аймаг — Булган аймаг	

Дэд сэдэв: Газрын зургийг уншъя

Анги: 4 дүгээр анги

Даалгавар	Хариултын мэдээлэл	Буруу хариултын шинж илгээ
1. Хэрэглэх түвшин	1 Дараах хоёр газрын зургийг харьцуулан ажиглаад дараах асуултанд хариулан бичээрэй.   а) Өөрийн оршин сууж байгаа аймгийнхаа газар нутгийг ямар өнгөөр илэрхийлсэн байгааг ажиглаад тохирох өнгүүдийг дугуйлаарай. б) Монгол орны газарзүйн зургийг сайтар ажиглаад дараах өгүүлбэрийн утгыг гүйцээн бичээрэй . • Манай орны зүүн хэсгээр талархаг гадарга зонхилж газарзүйн зурагт өнгөөр тэмдэглэгдсэн байна. • Манай орны баруун хэсгээр уулархаг гадарга зонхилж газарзүйн зурагт өнгөөр тэмдэглэгдсэн байна.	
2. Задлан шинжлэх түвшин	2 Дараах газар нутгийн хэмжээг уншиж танилцаад газарзүйн зурагт ямар өнгөөр тэмдэглэх вэ? Номныхоо 58-р хуудасны газрын зургийг ажиглаад тохирох өнгөөр дөрвөлжинг будаарай. а) Алтай нурууны ноён оргил Хүйтний оргил далайн түвшнээс дээш 4374 м өндөр өндөрт оршдог б) Мэнэнгийн тал нь далайн түвшнээс дээш 600 м өндөрт оршдог. с) Хэнтийн нурууны хамгийн өндөр цэг болох Асралт хайрхан уул нь далайн түвшнээс дээш 2799 м-т оршдог. д) Дархадын хотгор нь Хөвсгөл аймагт оршдог ба далайн түвшнээс дээш 1600 м өндөрт оршдог. 	